



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№35 /479/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.02.20

Цаг үе, үйл явдал

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ҮҮРГЭЭ НЭР ТӨРТЭЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЛБА ХААГЧДАД ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Турк Улсад эрэн хайх, аврах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон хүмүүнлэгийн тусламж үзүүлж байгаа алба хаагчидтай цахимаар холбогдов.

Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяр 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс хойш гүйцэтгэсэн үүрэг, цагийн нөхцөл байдлын талаар илтгэв.

Монгол Улсын баг нийт найман хүн /үүнээс хоёр хүүхэд/-ийг нуранги дороос гарган эмнэлгийн анхны тусламж үзүүлэн, 19 хүн /үүнээс зургаан хүүхэд/-ий цогцсыг гаргасан байна.

Хурандаа Ж.Сүх-Очиороо ахлуулсан цэргийн 11 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй

эмнэлгийн баг 72 хүүхэд, 359 эрэгтэй, 218 эмэгтэй, нийт 649 хүнд эмнэлгийн анхан болон лавлагаа шатны тусламж, үйлчилгээ үзүүлжээ.

Хүнд хэцүү цагт тусламжийн гараа сунгаж, хамтран ажиллаж байгаад БНТУ-ын холбогдох байгууллагуудын удирдлагууд Монгол Улсын төр, засаг, ард түмэнд чин сэтгэлийн талархал илэрхийлснийг багийн ахлагч, бригадын генерал Б.Ууганбаяр уламжлав.

Монголын ард түмний илгээсэн хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

Эх орон, ард түмнийхээ өгсөн үүрэг, даалгаврыг нэр төртэй биелүүлж байгаа багийн нийт бие бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн

Хүрэлсүх талархал илэрхийллээ.

Манай улсын хувьд анхны далайцтай, шуурхай, мэргэжлийн түвшний олон улсын эрэн хайх, аврах, эмнэлэг, хүмүүнлэгийн чиглэлээр үүрэг гүйцэтгэхдээ аюулгүй байдлаа сайтар хангаж байхыг захив.

Монгол Улсын эрэн хайх, аврах багийн үүрэг гүйцэтгэж байгаа Хатай мужийн Антакья хотод хүнд техникээр барилгын нурангийг цэвэрлэж зайлуулах, сэргээн босгох ажиллагаа эхлээд байна. Гэсэн ч эрчим хүч, дулаан хангамж, интернэт сүлжээ тасарсан, нийт барилга байгууламжийн 90 орчим хувь нь нурж сүйдсэн, газар хөдлөлтийн чичирхийлэл тасраагүй, нурангид өртөх эрсдэл өндөр байна.

Ахмад Д.БОЛОР

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-1	-18

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	26

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,524	3,530
EUR	3,775	3,798
CNY	511	515
RUB	46	46.50
JPY	26.30	26.65
KRW	2.71	2.76

### ЗУРХАЙ



2023.02.20 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 30

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

Эрлэг ЛУГАА Учирна

Наран УРГАХ, ШИНГЭХ:

07.51-18.21

Барилдлага:

Идэр

Шүтэн Барилдлага:

Авахуй

## ҮҮРГЭЭ НЭР ТӨРТЭЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЛБА ХААГЧИД ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



Бүгд Найрамдах Турк Улсын Хатай мужид эрэн хайх, аврах ажиллагаанд оролцсон 35 хүний бүрэлдэхүүнтэй баг дөнгөж сая эх орондоо газардлаа. Бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан угтан авч баяр хүргэв. Тэрээр энэ үеэр үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад "Цагийн хүрдийн баатрууд"-ын өргөмжлөлийг гардуулсан юм. Тус үйл ажиллагаанд ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, ОБЕГ-ын дарга хошууч генерал Г.Ариунбуян, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од болон бусад албаныхан оролцлоо.

Нийт 10 хоногийн хугацаанд үүргээ амжилттай гүйцэтгэсэн хурандаа Ж.Сүх-Очиороо ахлуулсан

цэргийн 11 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй эмнэлгийн баг 72 хүүхэд, 359 эрэгтэй, 218 эмэгтэй, нийт 649 хүнд эмнэлгийн анхан болон лавлагаа шатны тусламж, үйлчилгээг үзүүлсэн бол аврагчид маань нийт найман хүн /үүнээс хоёр хүүхэд/-ийг нуранги дороос гарган эмнэлгийн анхны тусламж үзүүлэн, 19 хүн /үүнээс зургаан хүүхэд/-ий цогцсыг гаргасан байна. Үүргээ амжилттай гүйцэтгэсэн баг эх орныхоо зүг мордохын өмнө амь насаа алдсан иргэдэд хүндэтгэл үзүүлэн нэг минут малгайгаа авч гашууджээ. Одоогоор ослын халуун цэгт амьд үлдэгсдийг эрэн хайх ажиллагаа явагдаж байгаа бөгөөд ОХУ, Япон, Польш зэрэг улсаас аврах багаа илгээгээд байгаа юм.

Ташрамд дурдахад, Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар

гамшигт нэрвэгдсэн Бүгд Найрамдах Турк Улс болон Арабын Бүгд Найрамдах Сири Улсын ард, иргэдэд улсын нөөцөөс бараа, материал, хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ дагуу БНТУ руу таван тонн махан нөөш, нэг тонн лаа, 1000 ширхэг хөнжил, 20 ширхэг иж бүрэн монгол гэрийг эхний ээлжид илгээсэн. Энэ цаг үед ч Монгол Улс

хүмүүнлэгийн тусламжийн бараа, бүтээгдэхүүний хандвийг цуглуулж илгээхээр бэлдээд байгаа билээ. БНТУ-ын холбогдох байгууллагуудын удирдлагууд хүнд хэцүү цагт тусламжийн гараа сунгаж, хамтран ажиллаж буй Монгол Улсын төр засаг, ард түмэнд чин сэтгэлийн талархал илэрхийлсээр байна.



Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 678,691,949

Эдгэрсэн

Нийт: 651,369,807

Нас барсан

Нийт: 6,791,079

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙН ЭМЧ, СУВИЛАГЧ НАР МААНЬ ӨӨРСДИЙН УР ЧАДВАРАА ДАЙЧЛАН АЖИЛЛАСАН



Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагч, Турк Улсад үүрэг гүйцэтгэсэн эмнэлгийн багийн ахлагч хурандаа Ж.СҮХ-ОЧИР:  
 -Цэргийн хүмүүс бид тушаалаар үүрэг биелүүлдэг. Энэ үүргээ ямар нэгэн алдаа мадаггүйгээр биелүүлэхийн тулд хичээж ажилладаг. Манай баг Турк Улсыг зорьсноос хойш 10 хоногийн хугацаанд 650 орчим хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлээ. Үүний 70 гаруй хувь нь хүүхэд, багачууд байсныг энд онцлох нь зүйтэй. Тэдгээр хүмүүс зөвхөн шархадсан, гэмтсэнээс гадна сэтгэл зүйн маш өндөр сорилыг давж байгаа нь харагдаж байлаа. Гар хөл нь шархдаж, толгой тархи нь хагарсан ч ээж, аав, үр хүүхэд, элгэн саднаа нуранги доороос хайж олохын тулд ямар их хүч гаргаж байгааг харах сэтгэл эмтрэм. Манай эмнэлгийн баг өгсөн үүрэг даалгаврын дагуу тасалдалгүйгээр 24 цагийн хугацаанд үүргээ гүйцэтгэсэн. Шөнийн цагт ч өвчтөнүүд олноор ирж эмчлүүлж байсан. Тэдний ихэнх нь юу болоод байгааг ч ойлгохгүй хэмжээнд хүртлээ ослын гүн шокод орсон байв. Энэ хүнд нөхцөлийг үл ажран эмч, сувилагч нар маань өөрсдийн ур чадвараа дайчлан ажилласан.

## БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Монгол түмний уламжлалт баяр, XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх харагчин /усан/ туулай жилийн сар шинийн баярыг угтан 2 дугаар сарын сарын 18-19-нд Батлан хамгаалах яам ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Ёслолын ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг нарын удирдлага, Ахмадын хорооны дарга бэлтгэл хошууч генерал Д.Магсаржав, эх орныхоо хөгжил дэвшил, улс орныг батлан хамгаалах үйл хэрэг, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө хөдөлмөр зүтгэлээ зориулсан ахмадууд оролцоо.

сэргээн сайжруулсан цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлого, шийдвэр гаргасан, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдмэл байдлыг хангасан зэрэг ололттой олон ажил, арга хэмжээг хэрэгжүүллээ" гэв.

Батлан хамгаалах салбарын хувьд 2022 онд "Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-аар батлуулж, Цэргийн тагнуулын газрыг ЗХЖШ-ын бүтцэд шилжүүлсэн. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэд хэдэн хуулийн төсөл дээр ажилласан.

"Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын даргад өргөн бариад байна.

Үүний зэрэгцээ "Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай" хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг холбогдох яамд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, "Цэргийн албаны тухай", "Дайны байдлын тухай" зэрэг салбарын томоохон хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байгааг салбарын удирдлагууд хэлсэн.

Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Дээрх бодлого, төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд эхнээсээ бодитоор хэрэгжиж эхэлснийг ч дурдлаа.

Тухайлбал, Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Сайдын дэргэдэх ахмадын зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагааг нь эхлүүлж, "Ахмадуудад эмнэлгийн тусламж үйлчилгээ болон биеийн тамир, соёл урлаг, архивын үйлчилгээ үзүүлэх журам"-ыг баталж мөрдүүлээд байна.

Мөн ахмадуудын дунд ихээхэн хүлээлттэй байгаа "Ахмадын хөгжлийн төв"-ийн барилгын бүтээн байгуулалтын ажлыг энэ оны эхний хагасд дуусгаж, ашиглалтад хүлээн авахаар бэлтгэж байна.

Арга хэмжээний төгсгөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Батлан хамгаалахын сайдын тушаалаар төрийн дээд одон, медаль болон салбарын шагналаар шагнагдсан ахмадуудад шагналыг нь гардуулан өглөө.

Ахмадууд салбарын бодлого, зорилт, үйл ажиллагааны үр дүнгийн хэрэгжилт, ил тод нээлттэй байдлыг сайшааж, оновчтой санал санаачилга бүрийг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн юм.

## АГААРЫН ТООСЖИЛТ, СТРЕСС, ӨВЧЛӨЛ МАШ ИХТЭЙ НӨХЦӨЛД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН

Цэргийн төв эмнэлгийн Аврахуйн анагаах ухаан хариуцсан орлогч дарга, дэд хурандаа Л.ЛУВСАНДОРЖ:

-Миний хувьд эмнэлгийн багаа хариуцаж, тухайн нөхцөл байдалд хэрхэн ажиллах талаар зохион байгуулалтыг нь хийсэн. Ослын голомтод байрлаж ажилласан учир агаарын тоосжилт, стресс, өвчлөл маш ихтэй нөхцөлд өвчтөнүүдээ эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Дийлэнх өвчтөнүүд нь ясны хугарал, зөөлөн эдийн гэмтэл, язрал үүссэн, шархнууд нь бохирдол ихтэй, учир нь өөрийн өвчнөө анзааралгүйгээр гэр бүлийнхнээ нурангаас гаргах ажилд оролцож байлаа. Орж ирсэн өвчтөнүүдийн заримынх нь зүрхний пулс 170-180 хүрч байсан нь зүрх зогсоход бэлэн болсон байсан гэсэн үг. Энэ нь олон хоног унтаагүй, маш их стресстэй нөхцөлд байсантай холбоотой. Бидний зүгээс өвчтөнүүдийг тогтворжуулаад дараагийн шатны эмчилгээг хийлгэхээр бэлтгэл ажлаа хангаж байсан хэдий ч өвчтөнүүд өөрсдөө эмчилгээгээ үл тоон гэр бүлээ нурангаас гаргах ёстой хэмээн гуйсан олон тохиолдол



гарсан. Бидэнтэй Турк болон Европын холбооны эмнэлгийн байгууллагын төлөөлөгчид ирж уулзан үүрэг гүйцэтгэх хугацаагаа дахиж сунган ажиллаж өгөөч гэж хүсэлт тавьсан. Бид бүхний зүгээс татгалзах зүйл байгаагүй ч Засгийн газрын шийдвэрээр тогтоосон хугацаанд ажиллахаас өөр боломжгүй байлаа.

## НУТГИЙН ИРГЭД ТАЛАРХСАН СЭТГЭЛ БИДЭНД УРАМ БОЛЖ БАЙЛАА



Цэргийн төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний эмч, дэслэгч П.ГАНЦЭНГЭЛ:

-Бид Монгол Улсын Засгийн газар болон БХЯ-наас өгсөн үүргийн дагуу БНТУ-д осолдогсод эмнэлгийн анхан болон лавлагаа шатны тусламж үйлчилгээг үзүүлэх зорилготой үүргээ амжилттай гүйцэтгээд ирлээ. Бид яс хугарсан, үе мултасан, олон тооны шарх авсан, сэтгэл санааны гүн хямралд орсон, өндөр настай хүмүүсийн архаг хууч нь сэдэрсэн, бэртсэнээсээ хойш олон хоног эмнэлгийн тусламж аваагүйгээсээ болж биеийн байдал нь нэлээн дордсон өвчтөнүүдийг хүлээн авч эмчилгээ хийсэн.




Миний хувьд 2021-2022 оны хугацаанд НҮБ-аас Өмнөд Судан Улсад явагдаж буй "UNIMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн нь үүсээд буй нөхцөлд ажиллахад давуу тал болж байлаа. Тиймдээ ч энэ удаагийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажиллагаанд багийн гэмтлийн бүлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний эмчээр үүрэг гүйцэтгэхэд ямар нэгэн саад тодгор байсангүй. Бидний байрлаж ажилласан газарт эмнэлгийн байр, байгууламжууд нь бүгд нурчихсан байсан учир осолд орсон, гэмтэж бэртсэн иргэдийн тоо маш их байсан. Бид очсон даруйдаа хагас өдрийн хугацаанд хээрийн эмнэлгээ дэлгээд үйл ажиллагаагаа шууд явуулж эхэлсэн. Нутгийн иргэд талархсан сэтгэлээ илэрхийлж байсан нь бидэнд урам болж байлаа.

## БИДЭНД ЯМАР НЭГЭН БАЙДЛААР АМРАХ, СААТАХ ЭРХ БАЙГААГҮЙ

Цэргийн төв эмнэлгийн Яаралтай тусламжийн эмч, дэслэгч Т.ОДХҮҮ:

-Ослын голомтод очиход манай эмнэлгийн багаас өөр тусламж, үйлчилгээ үзүүлэх өөр улсын багууд хараахан ирж амжаагүй байсан учир эмчилгээ, үйлчилгээ хэрэгтэй олон хүмүүс биднийг зорин ирж байсан.

Энэ хугацаанд бидэнд ямар нэгэн байдлаар амрах, саатах эрх байгаагүй. Ачаалал маш их байсан ч нутгийн иргэд, сири, арабчууд бидэнд талархсан сэтгэгдлээ илэрхийлж байсан нь биднийг улам бүр эрч хүчтэй болгож байлаа. Бид гамшиг, ослын маш хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн. Хаашаа л харна цогцос, хүндээр гэмтэж бэртсэн, ар гэрийнхнээ хайсан, алдсандаа цөхөрсөн хүмүүс байлаа. Үнэхээр зүрх зүсэм байсан.



\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
 \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
 \* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
 Индекс: 10018  
 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn  
 Утас: 70001029, 3412 (дотуур)